

ХУУРЧ БҮРЭНБАЯРЫН ХУУРДАН ХЭЛСЭН
“ГУРВАН УЛСЫН ҮЛГЭР”-ИЙН ЭХИЙН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА¹

М.Жавхлан

Удиртгал

Хэлний судлалын нэг чухал салбар нь үгийн сангийн судлал байдаг. Үгийн сангийн судлал хоцрогдвол хэл зүйн бусад судлалын салбарыг саатуулдаг билээ. Үгийн сангийн судлалыг ерөнхийд нь Ш.Баттөгс нар (2020) “уугуул үг, харь үг, харь хэлэнд орсон монгол үг хэмээн бүрэлдэхүүн хувааж үздэг. Тэгвэл үгийн сангийн нэгжийн талаас үгийн гарал, үгийн утга, хэлцийн, нэрийн, толь бичгийн хэмээн ангилдаг байна. Харин хэрэглээний талаас нь хуучин үг буюу түүхэн үг, шинэ үг, эерүүлэл буюу цээрлэл, этгээд үг, нэр томьёо буюу мэргэжлийн үгийн судлал” гэж хуваан үздэг байна.

Аливаа сурвалж бол түүнийг бүтээсэн ард түмэн, бие хүний бүтээлч сэтгэлгээ, бүтээх чадвар, тодруулбал, өөрийн бодол санаа, ухаарч ойлгосон, таньж мэдсэн зүйл, түүний ертөнцийг үзэх үзэл, ертөнцийг таньсан танилт нь уг бүтээлд нь биежин үлдэж, өвлөгдөн уламжилж байгаагаараа үнэ цэнтэй юм. Хуурын үлгэр бол түүнийг зохиосон, бас баяжуулан дэлгэрүүлж ирсэн хуурчийн аль алиных нь оюун санааны биежмэл ой санамж гэж үзэх ёстой. Тиймээс хуурч Бүрэнбаярын² хэлсэн “Гурван улсын үлгэр”-ийн үгийн санг задлан үзэж үг хэллэг, газар нутгийн онцлогийг нээн гаргахыг зорьсон болно. Ямар цаг үес, нийгэм-түүхийн ямар нөхцөлд, ямар зорилгоор тухайн сурвалж зохиогдож, түүнийг хайлан уламжилж ирсэн мэдээлэл бол чухал судлагдахуун болох нь эргэлзээгүй юм.

Бэнсний үлгэр бол аялгуулан хуурдаж хэлдэг аман уламжлалыг бичмэл хэлбэрт оруулаад, улмаар түүнийгээ дахин аман хэлбэрт аялгуулан хэлснийг соронзон хальсанд буулган бидэнд өвлөж ирсэн нь уг сурвалжийг өнгөрсөн цаг, одоо цагийн гэж хатуу зааглалгүйгээр, түүхэн бодит байдалд нь агуулга, бүтцийг нь иж бүрнээр тодорхойлох боломжийг бүрдүүлж болно.

Утга зохиолын зүйлс түүхийн судалгааны объект байж болох уу гэдэг асуудал Дерридагийн “текст”-ийг ойлгож тайлбарлах үзэл онолоос урган гарах болсныг бэнсний үлгэрийг сурвалж судлалын баримт хэмээн авч үзэхтэй хамаатай болгон тайлбарлаж болох билээ. Түүнчлэн аман сурвалжийг ямар учраас бичгийн хэлбэрт оруулав, эсрэгээрээ, бичмэл сурвалжийг ямар учраас аман хэлбэрт оруулав гэдэг асуудал ч сонирхолтой юм.

¹ Тус өгүүлэл нь БНХАУ-ын Нийгмийн шинжлэх ухааны суурь судалгааны анхаарагдаагүй буюу уламжлал тасарсан шинжилгээний салаагийн тусгай төсөл-Төвийн Үндэстний Их Сургуулийн Хятадын үндэстний уламжлалт соёлын солилцооны судлалын багийн төсөл болох “Монгол үндэстний аман уламжлал хийгээд монгол, хятад соёлын уусалцал” (20VJXT008)-ийн шатач чанартай бүтээл болно.

² Бүрэнбаяр хуурч нь 1928 оны 10 сарын 5-ны өдөр Өвөр Монголын Хянган аймгийн түшээт /хуурчин сүрэг хошуу/ хошуу “Хорчин баруун гарын дунд хошуу”-ны Төрөлж сумын Баянхуа гацааны баян тариачин урианхай аймгийн /Ү овогтон/ Содномпэлжээгийн хоёрдугаар хөвгүүн болон мэндэлжээ. Чагданбуу багшид шавь оруулж монгол, хятад, манж бичигт сургажээ. Эртний хятад хэлэнд нэвтэрсэн нэгэн болон боловсорч “зурхайт ном”, “мэргэдийн сургаал үгс” зэрэг ном төдийгүй эртний хятад түүх, үлгэрийг уншиж танилцан цээжилдэг байв. Ийнхүү бичгийн боловсролд нэвтэрсэн нь нэрт хуурч болоход нөлөөлсөн байна.

Монгол аман зохиолын дотор үлгэр, тууль, уртын дуу, ерөөл зэргийг энгийн ярианы хэлнээс боловсронгуй бичгийн зохиолоос илүү бодит дүрслэлтэй учир ард иргэд таашаан сонсож уламжлан хөгжүүлсээр иржээ. Хүүрнэн хэлж буй хүнээсээ эдгээр аман зохиолын хэлбэр нь үгний боловсролыг шаарддаг тул тухайн газар нутагтаа бичгийн өндөр боловсролтой, билиг авьяастай болон өвлөн тээж уламжлуулан хөгжүүлэх нь элбэг билээ.

Бэнсний үлгэр зэрэг ардын аман зохиолд зохиолтой шаардлагатай яг адил шаардлага тавьдаг.

Бичгийн зохиолч болгон хэлнийхээ дүрэм зүйг эвдэлгүй сахиж, үг бүрийг зохистой сонгож, өгүүлбэр бүрийг оновчтой найруулахыг хичээдэг бол ардын аман зохиолд ч эртнээс нааш уламжлагдан ирсэн эрхэмсэг хэлбэрийн үг хэл, дуудлага найруулгыг боловсруулсаар иржээ.

Огт бичиг үсэг мэдэхгүй хуурч нар хэлэхдээ үлгэрийг зааж өгсөн хуурч багш маань бас бичиг үсэг мэдэхгүй гэх нь олон тохиолддог. Энэ мэт мэтээр хүүрнэн хэлсэн үлгэрт ардын аман бичгийн хэлний хэлбэр мөн тов тодорхой баримтууд байна.

Бичгийн хэл “ном бичгийн хэл”, “аман бичгийн хэл” гэдэг хоёр зүйл хуваагдаж байна. Бид Бүрэнбаяр хуурчийн хэлсэн “Гурван улсын үлгэр”-ийн сурвалжийг аман бичгийн хэлэнд хамруулан үзсэн юм.

Хуурын үлгэр буюу бэнсний үлгэр 18-19 дүгээр зууны зааг дээр хорчин тал нутагт үүсэж Жарууд, Жиримийн чуулган, Баарин, Хишигтэн, Авга, Сөнөд, Баруун зүүн Үзэмчин улмаар монгол улсын Дорнод халх, Дарьгангын хошуугаар дамжиж, Богдын хүрээ хүртэл дэлгэрсэн байна.

Мин, Чин гүрний үеийн Хятадын эртний дөрвөн сонгодог зохиолын нэг “Гурван улсын үлгэр”-ийг Чин улсын сүүл үеэс орчуулан аман уламжлалаар монголчуудын дунд хүчтэй дэлгэрсэн байдгийг гадаад дотоодод хадгалагдан үлдсэн орчуулан дэвтэрлэсэн эх сурвалжаас баттай мэдэж болно.

“Гурван улсын үлгэр” нь монголчуудын дунд түгээмэл дэлгэрсэн нь 1980 оноос хойш юм. Өвөр монголын ихэнх аймаг хотын радио хорооноос шингээсэн дуу шингээлтийн текст нь голдуу дөрвөн хуурчийн “Гурван улсын үлгэр”-ийн доторх хэсэг агуулгыг сонгон хэлсэн бэнсний үлгэрийн нэвтрүүлдэг байв. Тэр нь даруй Бүрэнбаяр хуурчийн хуурдан хэлсэн “Гурван улсын үлгэр”, Жан Бөх хуурчийн хэлсэн “Гурван улсын үлгэр”, Шарав хуурчийн хэлсэн “Лю Бэй Жин Жөү орсон нь”, “Барсын жанжин Ма Чао”, Хайбаогийн хэлсэн “Дун Жуог сөнөөсөн нь” зэрэг дөрвөн бэнсний үлгэр юм. Үүний дотор Бүрэнбаяр хуурчийн хэлсэн “Гурван улсын үлгэр” бол хамгийн удаан цаг буюу 62 цаг хуурдсан, давхацсан тоогоор 280,000 орчим үгийн сантай, давхцаагүй тоогоор 21000 гаран үгийн сантай учраас үгийн сангийн задлал хийж ангилан судлахад тохиромжтой билээ. Тус үлгэр нь бусад хуурчийн хэлсэн “Гурван улсын үлгэр”-ээс ялгагдах онцлог нь хуурдан хэлэхдээ монголчуудын дур сонирхол, гоо таашаалд нийцүүлэхийн төлөө уул романыг дахин зохиомжилсон бүтээлч ажиллагаатай юм. Ингээд хятад эх, анхны монгол орчуулга, бэнсний үлгэрийн эх, орчин цагийн монгол орчуулгын эхийг харьцуулал болгон үгийн сангийн талаас шинжилсэн болно.

1. Гурван улсын үлгэрийн судалгааны тойм

Хятадын эртний үргэлжилсэн үгийн нэрт зохиолч Луо Гуань жунгийн туурвисан “Гурван Улсын Үлгэр” түүхэн роман нь Хятадын эртний дөрвөн сонгодог бүтээлийн нэг юм. Зохиолч Луо Гуань жун нь Юань гүрний сүүлч Мин гүрний эхэн үеэр буюу 1330-1400 оны хооронд Хятадын эртний Бэн жөү хотод¹ амьдарч байв.

Барууны орнуудад “Гурван улсын үлгэр”-ийн судалгаа өнгөрсөн зууны далаад оноос эхэлжээ. Төлөөлөх эрдэмтдийг нэрлэвэл, Оросын Ли Фүчин буюу Boris Riftin профессор,

¹ БНХАУ-ын Шаньси мужийн Тайюань хот

Английн судлаач Andrew West, Францын судлаач Claudine Salmon, Австралийн судлаач Ма Лань-ань нарын эрдэмтэн дурдагддаг болно.

“Гурван улсын үлгэр”-ийг анх 1689-1692 оны хооронд япон хэлнээ орчуулж эхэлснээс өнөөг хүртэл нийт хориод хэлээр орчуулсан байна. Үүнд: Англи хэлнээ орчуулагдсан хувилбаруудаас анхны бүрэн эхийн орчуулга Charles Henry Brewitt-Taylor (1857-1938)- ийнх юм. Хоёрдугаар бүрэн эхийн орчуулга нь Moss Roberts-гийн орчуулга болно. Jinhee Kim-ийн орчуулсан солонгос хэлний “Гурван улсын үлгэр” уншигчдын хүрээлэл хандлагыг ихэд хүлээж, ялангуяа сүүлийн жилүүдэд, “Гурван улсын үлгэр”-ийн олон хувилбар өргөн дэлгэрч, улс үндэстэн, үг хэл, соёл иргэншлийн зааг шугамыг саадгүй давж, нийтлэг ойлголт ололтыг хүртэж чаджээ.

Хятадын судлаачдаас Шэнь Бүе жүньгийн “Шинэ зууныг угтсан “Гурван улсын үлгэр”-ийн судалгаа 骆海辉,王海燕 (2012) -г дурдаж болох юм. Харин Вэнь Жүнь, Ли Бэйжя нарын 2011 онд авсан судалгаагаар, 1982-2010 он БНХАУ-д нийтэлсэн 文军,李培甲 (2011) “Гурван улсын үлгэр”-ийн англи орчуулгыг судалсан эрдэм шинжилгээний 70 гаруй өгүүлэл нийтлэгдээд байна.

“Гурван улсын үлгэр”-ийг арван есдүгээр зууны жараад онд анх манж орчуулгаас нь монгол хэлнээ орчуулсан гэдэг. Тухайлбал, 19 дүгээр зууны монгол үндэстний их зохиолч, нэрт монгол орчуулагч Инжинаш (1837-1892) монгол хэлнээ анх орчуулсан боловч орчуулсан эх олдсонгүй гэдгийг Тэмгэт “Гурван улсын үлгэр”-ийг орчуулах үеийн тэмдэглэлдээ бичсэн байдаг. Тэгээд 1928 онд Тэмгэтийн орчуулсан эх одоогийн хамгийн эртний бөгөөд бүрэн бүтэн орчуулгын хэвлэл болжээ.

Анх монгол хэлэнд Тэмгэт 1927 онд Бээжин хотноо хорголжин барыг үүсгэн байгуулж “Монгол бичгийн хэвлэлийн хороо”-ны үйл ажиллагааг удирдан байхдаа “Гурван улсын үлгэр” зэрэг Нангиадын хэд хэдэн сонгодог романыг тухайн үеийн хэвлэлийн шинэ технологиор хэвлэн гаргаж байсан түүхтэй юм. Түүнээс хойш Өвөр Монголын хэвлэлийн хороо 1950-1980-аад оны дундуур “Гурван улсын үлгэр” романыг хоёр удаа монгол бичгээр, 2013 онд кирилл бичигт Д.Болдбаатар (2013) хэвлэн гаргахдаа Тэмгэтийн хэвлүүлсэн хувилбарыг эх болгосон нь бидний судалгаагаар харагдаж байна.

Монгол орчуулгын дөрвөн янзын хувилбар байдгаас Монгол улсын үндэсний номын санд хадгалагдаж байгаа хоёр хувилбарыг нэрт манжич эрдэмтэн Мишиг, Б.Рифтин нар Дахайгийн орчуулсан манж эхтэй тулган судалж байсан билээ.

Монгол улсаас гадна Орос, БНХАУ, Герман, Дани, Америк, Япон, Унгар, Швед зэрэг улсуудад хадгалагдаж байна.

Түүхэн сурвалж бичгүүдээс үзэх юм бол манжийн мэргэн гүүш Дахай 1600-аад оны эхээр орчуулж байгаад дуусгаж амжилгүй бие барсан байна. Хожим түүнийг засгийн хэргийг шийтгэгч сайд Доргуны тушаалаар хожуу үеийн гүүш нар нөхөн гүйцээж, 1650 онд модон бараар Бээжин хотноо манж үсгээр хэвлэн найман тугийн цэрэг дайчдад цэргийн аргын ном болгон тарааж Дахайгаар овоглогдог энэхүү манж орчуулгыг хожим манай гүүш нар эх зохиол болгон ашигласан нь 1800-аад оны сүүл үе гэхэд хэд хэдэн хувилбараар бичгийн мэргэдийн дунд тархаж байжээ.

Бэнсний үлгэр, Гурван улсын үлгэрийн тухай Рифтин найруулж, Ян Ли Фан, Тянь Янь Чю 李福清著, 杨利芳,田艳秋译 (2014) орчуулсан “Зүүн монголын хуурч хийгээд хятад үлгэрчийн баатрын хүлэг морь дүрслэлийг адилтгах нь”, БНХАУ-ын эрдэмтэн Жюй Бао “Гурван улсын үлгэрийн монгол орон дахь тархалтын судлал” jүйi боо (2013) , БНХАУ-ын “Анхдугаар удааны хуурын үлгэрийн форум”-д “Хуурын үлгэр Гурван улсын үлгэр дэх Цао цаогийн дүр” jүйi боо (2013), Ши.Хасбаатарын “Гурван улсын үлгэрийн монгол аман зохиол дахь нөлөө” Qasabayatur, si.(2005), Цэлгэр “Бүрэнбаяр хуурчийн хэлсэн гурван улсын үлгэрийн

харьцуулсан судлал” Seleger (2020), “Хуурын үлгэр Гурван улсын үлгэрээс Хятад Монголын соёлын солилцоог ажиглах нь - ‘Жао зи лүн цэнээ поод ихээр байлдсан нь’ үлгэрийн жишээн дээр” 秀云 (2007), Шю юнь-ий “Хуурын үлгэр ‘Гурван улсын үлгэр’ доторх ‘Жао зи лүн цэнээ поод их л байлдсан нь’ гэдэг үлгэр дэх хятад соёлыг задлах нь” 秀云 (2011.3), Шю юнь ба Пен цүн мейгийн “Хуурын үлгэр Гурван улсын үлгэрийн монгол үндэстний утга урлаг, зан үйл дэх нөлөөг туршин өгүүлэх нь” 秀云 (2011.8) зэрэг дээрх судалгааны бүтээл, өгүүллүүд нь аман зохиол, уран зохиол, соёлын талаас судалсан байна. Эндээс үзэхэд бэнсний үлгэр болон хуурын үлгэрийн судлалд хэлний талаас үгийн сангийн задлал хийж, үгсийн тайлбар хийсэн судалгаа хараахан гараагүй байна.

2. Бүрэнбаяр хуурчийн хэлсэн “Гурван улсын үлгэр”-ийн агуулга

Б.Ринчений дэвшүүлсэн Монголыг судлагч нарын ажиглан тэмдэглэж чадаагүй тусгай нэгэн төрөл аман зохиол “бэнсний үлгэр” гэгчийг бий болгосон нь, Хятадын ардын роман түүхийг монголчлон хэлэгч тэдгээр үлгэрч-хуурч нар, монгол бичиг үсэг огт мэдэхгүй ч гэсэн, хүүрнэн ярихдаа жигтэй сайхан аман бичгийн хэлээр хэлдэг эл байдлыг онцлон тэмдэглүүштэй. Э.Вандуй (1956) Персийн түүхчин Рашид ад Дин, аль хэдийн, зургаан зуун жилийн өмнө тэмдэглэхдээ, монголчуудад тийнхүү аман бичгийн хэл бий гэж дурдсан нь, орчин үеийнхээ монгол бичгийн хэлний нэг уг сурвалжийг бидэнд зааж өгсөн ажээ. Тэгвэл бидний судалж буй Бүрэнбаяр хуурчийн 1984 оны 8 сард Хөлөн буйрын радио хороод шингээн нэвтрүүлсэн 62 цагийн “Гурван улсын үлгэр” хэмээх бэнсний үлгэрийн шингээлт нь аман бичгийн хэлний сурвалж болно.

Бүрэнбаяр хуурч тус бэнсний үлгэрийг шингээхэд хараагүй байсан тул тэр үед түүний хажууд шавилж байсан Эрдээ хуурч түүнд үлгэрийн бэнсийг уншиж өгсөн байна. Жюй бао 2012 оны 2 дугаар сарын 26 -ны өдөр Эрдээ хуурчийг утсаар сурвалжлахад “Тэр үед хэрэглэсэн дэвтэр бол монголоор орчуулсан гурван улсын үлгэрийг нэг удаадаа хамгийн багадаа 3 цаг, заримдаа 8 цаг хэлэх үлгэрийг нэг л доор уншаад өгчихнө. Олонхдоо үлгэр хэлэхээс өмнө нэг хоёр цагийн өмнө уншиж өгнө. Хэлэвч болно, хэлэхгүй боловч болно гэмээр агуулгыг нь хэлэхгүй. Заримдаа багш бас өөрөө үлгэр зохиож хэлнэ” хэмээн хэлсэн байна. Тус 62 цагийн үлгэр бол Тэмгэтийн орчуулгын 1-28 дугаар бүлгийн агуулга юм. Даруй шар алчууртны бослогоос Лю, Гуань, Жан ах дүү гурвуул Гү Чэн (古城) хотод цугларсан хүртэлх агуулгыг бичсэн байна.

Нийт 28 бүлгийн хураангуйлбал:

Хан овогтны төрийн доройтлыг Хан улсын төр Хуан ди, Лин ди хааны үед хүрэх үед тайганчуудыг итгэмжилснээр тэдний гарт засгийн эрх оров. Лин ди хаан таалал төгссөний дараа хэдийгээр арван Цэн ши сөнөөсөн боловч, засгийн эрх Дун Жувэгийн гарт шилжиж мөн түүнийг хороон Ли жяо, Хо сэ нар засгийн эрхийг авав. Мөн тэр хоёрын дараа Цао цаогийн засгийн эрхийг барив. “Хаан эзнийг өмнөө барьж, эл түшмэлийг эрхшээлдээ оруулсан” үнэн төрх илэрдэг. Тайганчуудын үймээний үед Хан хаанд хэсэгхэн эрх мэдэл байсан ч Дүн жүве, Ли жяо, Хо зувай, Цао цао нарын гарт засгийн эрх орсны дараа Хан хаан нэр төдий л байв. Харин Цао цаогийн сэргэсэн байдлыг анхны шар алчууртантай дайтаж байсан Чи ду юй түшмэлээс эхлээд Тун жуог устгасан гавьяа мөн Сянь ди хааныг Ли жяо, Хо зуайгийн гараас хамгаалсан зэргээс түүнийг улсын их жанжин бөгөөд Ү пин ба Хео өргөмжилсөн байна. Ингэснээр Цао цаод Хан улсын хэрэг явдлыг хаанаас өмнө мэдүүлдэг болсон байна. Харин Лю бейгийн тэнүүчлэлийн талаар Лю бей, Гуань юнь цэн ба Жан и детэй тоорын цэцэрлэгт хүрээлэнд ах дүү болж, хамтдаа Лю яны удирдлагад шар алчууртныг дайрсан, Лү зи, Жү жюнь зэрэг хүмүүсийн удирдлагад явсан ба Ан ши сянь, пин юань сянь зэрэг газар түшмэл хийж байсан тухай гардаг. Үүнээс гадна аргагүйн эрхэнд Цао цао, Юань шао нарын өмгөөлөлд багтаж байв. Эцэст нь Лю бей, Юань шаогаас салж, ах дүү дөрвүүл (лю, гуан, жан, жао)-аа Хө цэн хотод цуглардаг тухай өгүүлдэг байна.

Б.Ринчен “Уран зохиолын гол агуулга текстийн суурин дээр боссон монгол ардын аман бичгийн хэл” (1961)-ний зохиол болно. Цогт “Хуурын үлгэрийн үйл явдал бол хүмүүн ба орчин тойрон, хүмүүн ба хүний хоорондох харьцааг илрүүлсэн нэг буюу олон хэрэг учраар бүрэлдэж байдаг, үйл явдал нь хүний зан чанарыг дэлгэн үзүүлж, хуурын үлгэрийн утга сэдвийг илтгэн гаргадаг” (᠑᠙᠙᠓: 2002).

3. Бүрэнбаяр хуурчийн хэлсэн “Гурван улсын үлгэр” дэх зарим үгийг бусад орчуулгын “Гурван улсын үлгэр”-ийн эхтэй харьцуулах нь

Хуурын үлгэр /аман бичгийн зохиол/ ба бэнсний үлгэр /бичгээрх монгол эх үлгэр/, монгол орчуулгын үлгэрийн агуулга, үгийн санг харьцуулан судлах нь хуурчийн хэлний мэдлэг, тухайн нутгийн хэл аялгуу мөн хуурын үлгэрийн утга санааг нэн гүнзгий тайлж чадах билээ. Тэгвэл тус өгүүллийн гол сурвалж болох Бүрэнбаяр хуурчийн хэлсэн “Гурван улсын үлгэр”-ийн үгийн сангийн нэг бүрэлдэхүүн болон нутгийн аялгууны цөөн үгсийг Тэмгэт авгайн орчуулсан “Гурван улсын үлгэр”, Монгол улсын орчуулагч Д.Болдбаатарын “Гурван улсын үлгэр”-ийн илэрч буй үгстэй харгуулж үзэв. Жич: Бүрэнбаяр хуурч нь тухайн зохиолын агуулгыг хуурдан зохион хэлсэн болохоор бичгийн зохиолын үгийн сантай дүйхгүй учир үгийг хэрхэн орлуулан хувиргасныг доорх хүснэгтээс харъя.

№	Бүрэнбаяр	Авианы галиг	Тэмгэт	Д.Болдбаатар
1	ᠪᠠᠢᠬᠡᠭᠡᠢ	jo:nu:te:	байхгүй	байхгүй
2	ᠢᠷᠬᠡᠳᠡ	irxuele:	Ирэхэд /1-р дэвтэр 69-р хуудас/	ирэхэд
3	ᠲᠠᠷᠰᠠᠩᠳᠠ	da:rsɿn lɛ: ~ ta:rsɿnmi:	Таарсанд/1-р дэвтэр 125-р хуудас/	таарсанд
4	ᠴᠠᠳᠠᠬᠡᠭᠡᠳᠡ	fatxoɛlɛ:	Чадахгүйд/1-р дэвтэр 87 дугаар хуудас/	чадахгүйд
5	ᠣᠳᠤ᠐	mono:	Одоо/1-р дэвтэр 35-р хуудас/	одоо
6	ᠪᠦᠷ	xu: ~ xo:	Бүр /1-р дэвтэр 40-р хуудас/	бүгд
7	ᠥᠪᠴᠢᠨᠲᠡᠭᠡᠢ	yɓʃɿnte:ga:r dale:	Өвчинтэй /1-р дэвтэр 10-р хуудас/	өвчтэй
8	ᠤᠰᠡᠩᠭᠡᠢ	udʒsɿngue: ʃɔlɛ: ~ ʃɔlɔ:	Үзсэнгүй /1-р дэвтэр 218-р хуудас/	үзээгүй
9	ᠠᠪᠠᠭᠠ	jɛbgɿna:r dale:	Авга /1-р дэвтэр 5-р хуудас/	авга
10	ᠬᠦᠮᠦᠭᠦ	ɔlso:d	Хүмүүс /1-р дэвтэр 150-р хуудас/	хүмүүс
11	ᠲᠤᠮ	bɔdʒgɔ:	Их /1-р дэвтэр 152-р хуудас/	том
12	ᠮᠠᠰ	lɔ: lɔ:di:	Маш их/1-р дэвтэр 85-р хуудас/	маш том
13	ᠪᠠᠢᠬᠡᠭᠡᠢ	adɿlɛ:	байхгүй	байхгүй
14	ᠪᠠᠢᠬᠡᠭᠡᠢ	di:lu:gɿd	Байхгүй	байхгүй
15	ᠳᠢᠢᠯᠡᠬᠡᠭᠡᠢ	ʃɔlɔ:xue	Дийлэхгүй /1-р дэвтэр 55-р хуудас/	дийлэхгүй
16	ᠪᠣᠯᠠᠨ	bɔlɔ:d	Болон /1-р дэвтэр 2-р хуудас/	болон
17	ᠭᠠᠳᠠᠮᠵᠢ	ge:	Зээл /1-р дэвтэр 16-р хуудас/	гудамж
18	ᠨᠡᠯᠡᠭᠡᠳᠡ	naɣu:	Нэлээд /1-р дэвтэр 5-р хуудас/	нэлээд
19	ᠡᠭᠡᠵᠡ	ɣ:j ~ ɣ:jɛ:ga:n	Эх /1-р дэвтэр 5-р хуудас/	ээж

Хүснэгт №1. Нутгийн аялгууны үгс

Бидний судалгааны эх сурвалж нь харилцан адилгүй хоёр өөр уламжлал болохоор дан ганц цөөн үгийн жишээгээр харьцуулан үзэх нь өрөөсгөл юм. Тиймээс бид В.Инжинаш “Улаанаа уйлах танхим” романдаа “Шүлэг хэмээгч дурыг дагаж төрөгдмүй...Хэрэв урам төөрөгдвөөс даруй бэрх үгүй болмуй... Шүлэг зохиох нь нэгэн зүйлийн ухаан ормуй, бичиг олноор уншсанаар болохгүй... Хүсэлтэй сонин утга уянга хэмээгч хөх үүл салхинаа хөрвөх мэт, хүний сэтгэлийг хөдөлгөж эс чадваас хөнгөн бийрийг хөшиж юу хиймүй” хэмээн хэлсэн үгээр эш татан шүлгийн үгийн санг харгуулан үзсэн юм. Д.Галбаатар “шүлгийн уран санаа, онгод урам, билиг авьяас гол чухал үүрэгтэйг өгүүлсэн хэрэг юм” хэмээн хэлсэн байдаг (2012:519-520).

Тэгвэл Хятадын эртний дөрвөн том сонгодог роман дундаа, “Гурван улсын үлгэр” нь шүлэг найраг хачирласнаараа хятадын эртний үргэлжилсэн үгийн зохиолын өвөрмөц хэв намба бүхий сонгодог бүтээлийн төлөөлөл болжээ. “Гурван улсын үлгэр”-ийн хятад эхэд нийт 209 (192 шүлэг, 2 дуулал, 2 магтуу, 2 магтаал, 10 дуу, 1 хүүхдийн домог) бадаг шүлэг орсон байдаг ба эдгээр шүлэг уг романд маш гүн гүнзгий ач холбогдол үзүүлсэн гэдгийг судлаачид эрдэм шинжилгээний өдий төдий өгүүллээр судлан баталсаар байна.

Харин бидний сонгон авсан Бүрэнбаяр хуурчийн хэлсэн “Гурван улсын үлгэр”-т бусад монгол орчуулгатай харьцуулан үзэхэд дүйх гурван шүлэг илэрч байна. Бусад эхтэй харгуулан үзсэн шүлгүүдийг доорх хүснэгтээс үзнэ үү.

4. Бүрэнбаяр хуурчийн хэлсэн “Гурван улсын үлгэр” дэх шүлгийг “Гурван улсын үлгэр”-ийн бусад орчуулгатай харьцуулах нь

嫩草绿凝烟， 袈裟双飞燕。洛水一条青， 陌上人称羨。 远望碧云深， 是吾旧宫殿。何人仗忠义， 泄我心中怨！ 4-р бүлэг	
Бүрэнбаяр	Өнөөдөр нь тэнгэрийн өмнө нь тэнгэр гүж Өмнөд тэнгэр тэнгэрийнхөн Өмнөд тэнгэрийн Өмнөд тэнгэрийнхөн Өмнөд тэнгэр тэнгэрийнхөн Тэнгэр өн тэнгэрийнхөн Өмнөд гүж Өмнөд өн гүж тэнгэрийнхөн тэнгэрийнхөн Өмнөд гүж Тэнгэр тэнгэр Luo river (洛河) Өмнөд тэнгэрийнхөн тэнгэрийнхөн Өмнөд тэнгэрийнхөн Өмнөд тэнгэр тэнгэр гүж Өмнөд тэнгэрийнхөн гүж Өмнөд тэнгэр өн гүж Тэнгэр өн тэнгэр тэнгэр өмнөд тэнгэр Тэнгэр тэнгэр гүж тэнгэр тэнгэр тэнгэр өн Өмнөд тэнгэрийнхөн Тэнгэр тэнгэр өн Өмнөд тэнгэр тэнгэр тэнгэр тэнгэр өн Өмнөд Тэнгэр өн Өмнөд тэнгэр өн тэнгэр тэнгэр тэнгэр өн Өмнөд Тэнгэр өн Өмнөд тэнгэр өн Өмнөд тэнгэрийнхөн тэнгэр гүж тэнгэрийнхөн Тэнгэр өн тэнгэр гүж тэнгэрийнхөн өн Өмнөд тэнгэр гүж тэнгэр тэнгэр өн Өмнөд 14-р цаг
Тэмгэт Хуудас 66	Хөх өвсөн соёолон утаарсны дээгүүрээ Хүрээний хараацай тойрон хослон нисмүй Хөвөө урт Луо усан нэгэн зурвас хөхөвтөр Хөдөө талын хүмүүн нар бахдан хэлэлцэх бөлгөө. Хөхөмдөг үүлний гүнийг холоос харахулаа Хөөрхий миний хуучин ордон харш булай Хүчилж шударга журмыг хэн хүн гүйцдэгээ Хөөгдсөн миний хэвлийн доторх хорслыг алдруулмуй.
Д.Болдбаатар Хуудас 75	Хөх өвсөн соёолон униартсаны дээгүүр Хүрээний хараацай хосолж тойрон ниснэ Хөвөө урт Луо усан нэгэн зурвас хөхөвтөр Хөдөө талын хүмүүн бүгд бахдан хэлэлцэнэ. Хөхөмдөг үүлсийн гүнийг холоос харахул Хөөрхий миний хуучин ордон харш болой Хүчилж шударга журмыг ямар хүн гүйцээгээд Хөөгдсөн миний хэвлийн доторх хорслыг алдруулмуй.

Хүснэгт №2. I шүлэг

Тус шүлэг бол Луо Гуаньжунгийн бичсэн таван үгт хэмнэлтэй шүлэг болно. Дүн Жүе Хань гүрний бага хаан Лю Бангийн хаан суурийг булааж, эрх чөлөөг нь хязгаарлан хорьжээ. Тэгээд хоригдон гансарсан Лю Бан хаврын хараацайг хараад ийн шүлэглэжээ. Хоёр орчуулгын хувьд

Хүснэгт №3. II шүлэг

Монгол судлал-XLVI (587)

红牙催燕拍飞忙，一片行云到画堂。 眉黛促成游子恨，脸容初断故人肠。 榆钱不买千金笑，柳带何须百宝妆。 舞罢隔偷目送，不知谁是楚襄王。 8-р бүлэг	
Бүрэнбаяр	ᠠᠨᠠᠭᠠᠨ ᠬᠠᠪᠲᠤᠰ ᠠᠶᠤᠰ ᠲᠠᠭᠠᠷᠤᠭᠤᠯᠠᠭ ᠳᠤᠷ ᠨᠢᠰᠢᠬᠤ ᠬᠠᠷᠠᠭᠠᠳᠠᠢ ᠶᠠᠷᠲᠠᠢ ᠤᠭᠠᠯᠵᠠᠯᠵᠠᠰᠠᠨ ᠤᠯᠤᠰ ᠨᠢᠭᠡᠨ ᠬᠡᠰᠢᠭ ᠵᠤᠷᠠᠮᠤᠯ ᠲᠠᠨᠬᠢᠮ ᠳᠤᠷ ᠣᠷᠠᠮᠤ ᠬᠥᠮᠰᠡᠭᠨᠢᠶ ᠬᠠᠷ ᠲᠡᠨᠡᠮᠡᠯ ᠬᠤᠮᠤᠭᠤᠨᠢ ᠬᠣᠷᠰᠤᠯᠢᠭ ᠥᠳᠥᠵᠡ, ᠴᠠᠷᠠᠶᠢᠨ ᠴᠠᠭᠠᠨ ᠬᠤᠭᠤᠴᠢᠨ ᠨᠥᠬᠤᠷᠢᠶᠢᠨ ᠭᠣᠷᠢᠭᠢᠭ ᠲᠠᠰᠠᠯᠠᠮᠤᠢ ᠬᠠᠢᠯᠠᠭᠠᠰᠤᠨ ᠵᠤᠭᠠ ᠮᠢᠶᠨᠭᠠᠨ ᠯᠠᠩᠭᠢᠨ ᠢᠨᠡᠭᠡᠳᠢᠶᠢᠭ ᠬᠢᠷᠭᠢᠬᠤᠭᠢ ᠪᠦᠷᠭᠠᠰᠤᠨ ᠨᠠᠪᠴᠤ ᠵᠤᠭᠤᠨ ᠡᠷᠳᠡᠨᠢᠶᠢᠨ ᠵᠢᠮᠰᠡᠭᠢᠭᠢᠭ ᠬᠡᠷᠢᠭᠢᠭᠢᠬᠤᠭᠢ ᠪᠦᠵᠢᠭᠢᠭᠢᠭᠢ ᠳᠤᠭᠤᠰᠠᠨ ᠬᠣᠶᠢᠨ ᠬᠤᠯᠭᠠᠢ ᠨᠠᠳᠤ ᠬᠢᠷᠭᠢᠬᠤᠭᠢ ᠢᠨᠤ ᠪᠦᠷᠬᠡᠭ ᠴᠤ ᠤᠯᠤᠰᠤᠨ ᠰᠢᠶᠠᠨ ᠪᠠᠨ ᠴᠤᠬᠠᠮ ᠬᠡᠨ ᠪᠣᠯᠣᠬᠤᠭᠢ ᠮᠡᠳᠡᠬᠤᠭᠢ. 22-р цаг
Тэмгэт Хуудас 143	Улаан хавтас аяс тааруулах дур нисэх хараацай яартай Угалзалсан үүлс нэгэн хэсэг зурмал танхим дур ормой Хөмсөгний хар тэнэмэл хүмүүний хорслыг өдөж, Царайн цагаан хуучин нөхрийн горийг тасалмуй Хайлаасны зуга мянган лангийн инээдийг хүргэхүй Бургасны навч зуун эрдэнийн жимсэгийг хэрэглэхгүй Бүжиглэж дууссан хойно хулгай нүд хүргэх ину Бүрхэг Чү улсын Сян ван чухам хэн болохыг мэдэхгүй.
Д.Болдбаатар Хуудас 151	Улаан товшуурын аяс тааруулан нисэх хараацай яарахуйд Угалзалсан үүлс нэгэн хэсэг зурмал танхимд ормуй Хархан хөмсөг тэнэмэл хөвгүүний хорслыг өдөөж Хасын царай хуучин нөхрийн горийг тасалмуй Уяхан хайлаасны навч мянган лангийн инээдийг хүргэхүй Туяхан бургасны навч зуун эрдэнийн энгэсгийг хэрэглэхгүй Бүжиглэж дууссан хойно хулгай нүдээр харах нь Бүрхэг шөнийн дунд Чү улсын Сян ванг эрэлхийлэх мэт.

Хүснэгт №3. III шүлэг

Энэ мөн Дяо Чаньгийн гоо үзэсгэлэнтэй, уяхан туяхан байдлыг магтсан дуулал болно. Хоёр монгол орчуулган хувьд хуучин орчуулга нь гол үгнүүдийг нь оноож, утгыг товч тодорхой илэрхийлэхийг хичээсэн бол шинэ орчуулга нь монгол шүлгийн толгой холболт, хэм хэмнэлийг тэнцүүлэх үүднээс гол өгүүлэгдэхүүнээ тодорхойлох үгнүүдээрээ толгой холбожээ. Үүнд “游子” гэдгийг “тэнэмэл хүмүүн, тэнэмэл хөвгүүн” гэдгийг аль нь ч оновчтой санагдахгүй байна. Харин “хэсүүлч хүмүүн, хэсүүлч хөвгүүн” гэх нь онох юм шиг. “故人肠” гэдэг нь манай монгол сэтгэлгээнд “элэг зүрхийг таталдуулсан” гэсэн утгатай болохоор “Хасын царай хуучин нөхрийн горийг тасалмуй” гэсэн орчуулга маш дүрслэл сайтай болжээ. “榆钱不买千金笑，柳带何须百宝妆” гэдэг нь хайлаасны зугаа шиг олон мөнгөөр ч Дяо Чаньгийн нэг инээхийг хүрэхгүй, бургасны мөчир навч шиг засал жимсээр гоёсон ч Дяо Чаньгийн өнгө зүсийг гүйцэхгүй гэсэн утгаар Дяо Чаньгийн үзэсгэлэн гоог илэрхийлсэн байдаг. Дээрх хоёр орчуулгад харин утга маш балархай байна. Бүрэнбаяр хуурчийн хэлсэн шүлэгт “Улаан хавтас аяс тааруулах дур нисэх хараацай яартай” эхний мөрөөс “аяс” хэмээх үгийг “ᠠᠨᠠᠭᠠᠨ” гэж сольсон байна. Хоёр дахь “Угалзалсан үүлс нэгэн хэсэг зурмал танхим дур ормой” хэмээх мөрнөөс “ᠴᠤᠯᠠᠭᠠᠯᠵᠠᠯᠵᠠᠰᠠᠨ” хэмээх үг нэмэн “ормуй” хэмээх үгийг “ᠣᠷᠠᠮᠤ” гэж сольжээ. Тав, зургаадугаар мөрийг гурав, дөрөвдүгээр мөрд шилжүүлэв. Мөн хоёр, гуравдугаар мөрийг тав, зургаадугаар мөрд шилжүүлэн долоодугаар мөрийг хасан наймдугаар мөрийг оруулсан байна.

Дүгнэлт

Б.Ринчен бээр “Дэлхий дахины уран зохиолын гайхамшигт эрдэнэсийн санд орж байгаа Хятадын уг нутагтаа үй түмэнд алдаршсан роман гэдэг түүх бичиг, тууж, туурь гэдэг бичгийн үлгэр зэрэг сайхан зохиолыг оросын Пушкин, Лермонтовын үеийн манай монгол бичгийн хүмүүс, Ар Өвөр Монголын аль алинд нь ч, заримдаа зэрэгцэн орчуулж байсан нь, тухайнхаа цаг үест шарын шашны дарангуйлан хэцүүдүүлж байсан хүлээсийг алдруулахад нөлөөлөх дэвшилт үзэгдэл байж билээ. Нангиад уран зохиолын эдгээр орчуулгыг хүн өдий төдийгөөр нь хуулан, бичиж чаддаггүй нэг нь агт мориор арилжин авч, бахархан үздэг уншдагийг нь сонсогчид, тэр дороо тогтоон цээжилж, бусдад ярьж өгдөг нь манай аман бичгийн хэлийг баяжуулагч аман зохиолын бичиг тархаж байсан тэр сонин үзэгдлийг монгол утга зохиол судлаачид анзааран үзүүштэй байна” (Э.Вандуй, 1956:39-70) хэмээн цохон дурдсан байна.

Тэгэхээр тухайн цаг үед Нангиадын сонгодог уран зохиолуудыг монгол хэлнээ уран яруу орчуулан түгээх болсон шалтгаан илхэн харагдаж байна.

Хоёр монгол орчуулгыг хятад эхтэй нь үгийн санг харьцуулсны дүнд, хуучин орчуулга нь хятадын эртний шүлгийн үг хэллэг товч авсаархан, утга уянга яруу тод байдаг онцлогийг мөрдөж, утгыг зөв оновчтой илэрхийлэх, үг үсгийн тоо хэмжээ, хэм хэмнэлийг тэнцүүлэн орчуулахыг анхаарчээ. Гэхдээ “Гурван улсын үлгэр” романд орсон шүлгүүд хятадын эртний Тан гүрний шүлэг зэрэг төлөөлөх хэв намба бүхий шүлгүүдийг бодвол ойлгоход харьцангуй хялбар, үгийг шууд утгаар нь хэрэглэсэн тохиолдол харагдаж байна. Мөн ихэнх байдалд, үйл явдлаа хураангуйлан оновчтой үгсийг сонгон уншигчдад хүргэсэн байна. Иймээс Тэмгэтийн эдгээр онцлог шинжийг нь сайн ойлгож, олонхдоо үгийн утгыг мөрдөн орчуулахаар голложээ. Түүнийхээ хажуугаар улируулж орчуулах, орлуулж орчуулах, бодитой орчуулах ба хийсвэрлэн орчуулах зэрэг аргуудыг уялдуулснаар, шүлгийн санаа ахуй, хэм хэмнэл зохицож, эх зохиолдоо үзүүлэх үүрэг чадавхыг нь гүйцэтгэж чаджээ. Хэл хэллэгийн хувьд, өнгөрсөн зууны эхээр орчуулагдсан гэдэг утгаараа, тухайн цаг үеийн хэл найруулгын хэв намба ба эртний уран зохиолын хэл хэллэгийн онцлогийг хадгалжээ. Мөн монгол шүлгийн толгой холбох, сүүл дарах ёсонд нийцүүлэн орчуулахыг хичээсэн нь илэрхий байлаа. Харин Д.Болдбаатарын шинэ орчуулга нь өнөө цагийн монголчуудад зориулагдсан учраас хэл найруулгын хувьд орчин цагийн монгол хэлээр орчуулагдсан нь цаг үеийнхээ хэрэгцээ шаардлагад нийцсэн бүтээл болохын чухал шалгуур болсон гэж үзэж болох юм. Гэвч орчуулагч Д.Болдбаатарын “Гурван улсын үлгэр” нь Тэмгэтийн орчуулгыг хөрвүүлэн найруулж, үг хэллэгийг халх аялгуунд тохируулан хувиргасан нь тод харагдаж байна. Тиймээс Д.Болдбаатар орчуулагч хэдийгээр хятад хэлний бичгийн өндөр боловсролтой боловч Тэмгэтийн орчуулгыг хөрвүүлэн бүтээлээ хийсэн хэмээн үзэж байна. Харин бидний гол аман бичгийн сурвалж болох Бүрэнбаяр хуурчийн хэлсэн “Гурван улсын үлгэр” нь Тэмгэт авгайн орчуулсан “гурван улсын үлгэр”-ийн дэвтрийн хуулбар эхийг сонсож, шинээр найруулан зохиосон бөгөөд орчуулгын агуулга, орчуулгын дэвтэр дэх үгсийг өөрийн үгийн сангаар баяжуулан хувиргасан, дүйх гурван шүлгийн үг хэллэг таарч буй зэргээс тод харагдаж байна. Бүрэнбаяр хуурч нь хуурдан хэлэхдээ өөрийн нутгийн аялгууны үг хэллэгийг ашиглан сонсогч түмэнд улам ойлгомжтой, бэнсний үлгэрийн уламжлалыг баримтлан зөв оновчтой үгсийг сонгож, уран сайхан найруулсан хэлсэн нь харагдаж байна.

Ном зүй

- Баттөгс Ш., Пүрэвжав Э., Гэрэлмаа Г., Шинэбаяр О., Ганболд Д.** 2020. *Монгол хэлний үгийн сан найруулга судлал*. Монгол хэл судлалын түүх III боть. Улаанбаатар.,
骆海辉,王海燕. 2012. 《三国演义》与中国文化,绵阳师范学院外国语学院讲师,四川绵阳 621000.
- 文军,李培甲. 2011. 国内《三国演义》英译研究:评述与建议[J].北京第二外国语学院学报,(8).
- Болдбаатар Д.** 2013. *Гурван улсын үлгэр*. Улаанбаатар.,
李福清著,杨利芳,田艳秋译:东蒙说书艺人与汉族说书艺人对英雄坐骑描述的比较.内蒙古师范大学学报. 2010 年第4期.
- Вандуй Э.** 1956. *Хэлээ хайрлан энхрийлж, үгний боловсролыг эрхэмлэе*. Монгол хэл бичгийн зарим асуудлууд. Улаанбаатар. х 39-70.
- Галбаатар.Д (2012).Уран зохиол нэвтэрхий толь. Улаанбаатар.,
- Jiui boo.** 2013. *γurban ulus-un üliger-ün mongγol orun daki tarqalta-yin sudulul [Гурван улсын үлгэрийн монгол орон дахь тархалтын судлал]. Öbür mongγol-un keblel-ün qorig-a, Kökeqota.,*
- Jiui boo.** 2013. *Quγur-un üliger 'γurban ulus-un üliger' daki coo coo-yin düri [Хуурын үлгэр 'Гурван улсын үлгэр' дэх Цао Цаогийн дүр]. angqaduγar udayan-u quγur-un üliger-ün forum. 2013 on-u 10 sar-a-yin 12-un edür, dotuγadu materiγal.*
- Qasbayatur, si.** 2005. *γurban ulus-un üliger-ün mongγol aman jokiγal daki nölüge [Гурван улсын үлгэр'-ийн монгол аман зохиолдох нөлөө]. Öbür mongγol-un yeke surγayuli-yin erdem sinjilgen-ü sedkül. 2005 on-u 5 duγar quγu᠑aγ-a.*
- Čeleger.** 2020. *Bürinbayar quγurči-yin kelegesen γurban ulus-un üliger-ün qari᠑ayuluγsan sudulul [Бүрэнбаяр хуурчийн хэлсэн гурван улсын үлгэрийн харьцуулсан судлал]. Begejing.*
- Čoytu.** 2002. *Quγur-un üliger-ün sudulul [Хуурын үлгэрийн судлал]. Begejing.*
- 秀云. 2007. 从胡仁乌力格尔〈三国演义〉看蒙汉文化交流-以〈赵子龙大战长坂坡〉为例.通辽市.
- 秀云.胡仁乌力格尔三国演义之赵子龙大战长坂坡对汉文化继承的剖析,西部蒙古论坛,2011年第3期.
- 秀云、彭春梅.试论胡仁乌力格尔三国演义对蒙古族文艺、民俗的影响,赤峰学院学报,2011年第8期.
- Ринчен.Б.** 1961. *Монгол ардын аман бичгийн хэл*. “Шинжлэх ухааны академийн мэдээ” сэтгүүл. №2, Улаанбаатар. х 109-116.

Abstract

Oral tales, which are known as “tales of the fiddle” (*quyur-un üliger* or *bengasün-ü üliger*) derived in the eastern part of Inner Mongolia, are well-inherited to this day and have been the focus of many Mongolist scholars since long ago. Although many international scholars studied the tales of the fiddle from different perspectives, there is a lack of study on lexicological components in the tales of the fiddle.

In this paper, author chose the “Romance of the Three Kingdoms (in Mongolian: *γurban ulus-un üliger*; in Chinese: 三国演义)” which was performed by Bürenbayer bard (*quyurči*, Lit: the fiddle player) as a research object. It was broadcasted by the Khulun Buir Radio Committee for a total of 62 hours length in August 1984. The author considered these materials as oral sources (transcriptions of audio recordings) for his research and conducted a comparative lexical analysis between the original Chinese text and other Mongolian translations.

The Chinese source of the “Romance of the Three Kingdoms” contains 209 stanzas (192 poems, 2 hymns, 2 panegyrics, 2 eulogies, 10 songs, 1 children's tale), 3 of which correspond to the selected tale of the fiddle. In addition, the vocabulary items of the bards and some words of the local dialect were compared with the words used in two other translated versions of the “Romance of the Three Kingdoms”, which were translated by Temget and D. Boldbaatar translated from Chinese into Mongolian.

In this article, the author not only summarizes the study of the “Romance of the Three Kingdoms” and its translation into Mongolian, but also compares Burenbayer's tale of the Fiddle with other Mongolian translations of the “Romance of the Three Kingdoms” in terms of lexical components and features of poetry, and it was determined that the tale of the fiddle originated from Temget's translation of the Romance of Three Kingdoms.

Keywords: *Tales of the Fiddle” (quyur-un üliger), Romance of the Three Kingdoms, Lexical components*